



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 01 дугаар
сарын 31 -ны өдөр

№ 01

Улаанбаатар хот
Утас: 262629

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8, Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.11, 5.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийн хуваарийн төслийг хэлэлцээд 2019 оны төсвийн гүйцэтгэлийг нэгдүгээр, 2020 оны төсвийн хуваарийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн даргад зөвлөмж болгосугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т тусгах нэмэлт, өөрчлөлтийг гуравдугаар хавсралт ёсоор баталсугай.


3. Залуучуудыг тогтвортой ажлын байраар хангаж байгаа ажил олгогчийг дэмжих, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тусгайлсан хөтөлбөр, арга хэмжээний санал боловсруулж, танилцуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т, сум, хороонд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүний нөөцийг оновчтой зохион байгуулах талаар санал танилцуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/-т тус тус даалгасугай.


4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

5. Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, зөвлөн туслах, мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг улирал бүр тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
САЙД  С.ЧИНЗОРИГ



Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн
дарга  Д.ХАДХҮҮ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

Нэг. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

- 1.1. Хөтөлбөрийн 10.2-т “..., Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар туршилтаар Ажил, мэргэжлийн мэдээллийн төвд төрийн бус байгууллагаар дамжуулан...” гэснийг хасах;
- 1.2. Хөтөлбөрийн 10.4-т “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ...” гэснийг хасах.

Хоёр. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”

- 2.1. Хөтөлбөрийн 6.1-д “... дараах байдлаар 1-2 удаа зохион байгуулж, хэрэгжүүлнэ.” гэснийг “... дараах байдлаар жилд 2-с доошгүй удаа зохион байгуулж, хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөх;
- 2.2. Хөтөлбөрийн 6.1.3-ийг “Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэс гарааны бизнес эхлүүлэх хүсэлтэй залуучууд (их, дээд сургууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагч, төгсөгчид, 15-34 насны залуучууд)-дад мэдээлэл хүргэх, бүртгэх, бүлэг байгуулах арга хэмжээг хариуцах ба мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын бүлгийг сургалтын байгууллагатай нь хамтран зохион байгуулна” гэж өөрчлөх.

Гурав. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”

- 3.1. Хөтөлбөрийн 5.6 дахь хэсгийг “Ажил олгогч болон гэрээт малчин өрхийн нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлыг тухайн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нөхөн олгоно. Гэрээт малчин хувь хүний орлогын албан татварыг өөрөө төлнө.” гэж өөрчлөн найруулах;
- 3.2. Хөтөлбөрийн 5.7 дахь хэсгийг “Нөхөн олговрыг малчин ажил олгогч болон гэрээт малчны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримт, энэхүү хөтөлбөрийн 5.4-т заасан гэрээг үндэслэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд хуваарилсан хөрөнгөөс олгоно.” гэж өөрчлөн найруулах;
- 3.3. Хөтөлбөрийн 5.12.1 дахь заалтыг “Шилжин очиж байгаа аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар гэрээт малчин өрхийн тухайн орон нутагт нүүж очих зардлыг Хөдөлмөр, нийгмийн


хамгааллын сайдын баталсан зардлын жишгийг үндэслэн олгоно.” гэж өөрчлөн найруулах.

Дөрөв. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

- 4.1. Хөтөлбөрийн 3.2.5-д “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс...” гэсний дараа “..., Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар...” гэж нэмэх;
- 4.2. Хөтөлбөрийн 3.3.3-т “... нийслэлд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, ...” гэснийг “... нийслэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, ...” гэж өөрчлөх;
- 4.3. Хөтөлбөрийн 3.4.7-д “... 5.0 хүртэл сая төгрөг...” гэснийг “... 1.0-5.0 хүртэл сая төгрөг...” гэж, “... 100 хувь эргэн төлнө.” гэснийг “... 50¹ хувийг эргэн төлнө.” гэж тус тус өөрчлөх;
- 4.4. Хөтөлбөрийн 3.5.1-д “Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ...” гэсний дараа “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар ...” гэж нэмэх;
- 4.5. Хөтөлбөрийн 3.5.5-д “... Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ...” гэсний дараа “... Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар...” гэж нэмэх;
- 4.6. Хөтөлбөрийн 3.7.3-т “... сургалтыг Улаанбаатар хотод Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, ...” гэснийг “... сургалтыг Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, ...” гэж өөрчлөх;
- 4.7. Хөтөлбөрийн 3.7.6-д “Мэргэжлийн сургалт зохион байгуулах байгууллагын сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах танхим, хэрэглэгдэхүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хянаж, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын мэргэшсэн байгууллагуудын жагсаалтыг гаргана.” гэсэн заалтыг нэмэх;
- 4.8. Хөтөлбөрийн 4.3.1-т “... 50.0 хүртэл сая төгрөгийг...” гэснийг “... 10.0-20.0 хүртэл сая төгрөгийг...” гэж өөрчлөх;
- 4.9. Хөтөлбөрийн 4.3.2-т “... 30.0 хүртэл сая төгрөгийн” гэснийг “... 5.0-20.0 хүртэл сая төгрөгийн...” гэж өөрчлөх.

¹ Засгийн газрын 2016 оны 276 тогтоолын хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.3 дахь хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн
01 дүгээр тогтоолын нэгдүгээр хэвсрэлт



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ


№	Үзүүлэлт	2019 оны төлөвлөгөө		2019 оны гүйцэтгэл		Хувь	
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө		
1	Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө		28,500,000.00		9,100,000.00	31.9%	
2	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж		11,137,820.00		11,137,820.00	100.0%	
3	Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого		19,836,400.00		54,348,716.05	274.0%	
4	ХБИ ажиллууллагүйн төлбөрийн орлого		1,000,000.00	1,158	3,682,605.98	368.3%	
5	Жижиг зээлийн эргэн төлөлт		20,000,000.00		25,350,000.00	126.8%	
6	Жижиг зээлийн хүү, алданги				67,233.12		
7	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт			8,554	12,434,526.70		
8	Бусад/Акт албан шаардлага/				29,549.41		
9	Өмнөх оны үлдэгдэл		14,046,003.00		44,113,294.42	314.1%	
Орлогын нийт дүн			94,520,223.00	9,712	160,263,745.67	169.6%	
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээ		940,000.00	118,584	789,248.35	84.0%	
2	Ажилд зуучлах үйлчилгээ		940,000.00	44,059	546,155.02	58.1%	
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	4040	181,800.00	3,905	164,369.00	90.4%
		Үйлдвэрлэл дээрх сургалт	640	448,000.00	700	253,827.00	56.7%
		Мэргэжлийн болон давтан сургалт	2180	501,400.00	2,748	468,419.89	93.4%
		Дүн	6860	1,131,200.00	7,353	886,615.89	78.4%
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	1535	7,676,000.00	2,013	7,580,500.00	98.8%
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	5000	150,000.00	5,079	134,337.00	63.9%
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		516,240.00	1,206	341,005.34	66.1%
		Ажил олгогчид олгох дэмжлэг	282	1,084,000.00	202	669,881.90	61.8%
		Нийтийг хамарсан ажил	12392	3,470,000.00	15,273	3,113,380.29	89.7%
		Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ	746	1,400,000.00	1,106	875,400.10	62.5%
		Цагийн ажилд зуучлах	15000	105,000.00	18,778	84,826.76	80.8%
		Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	2000	1,000,000.00	2,071	942,475.35	94.2%
Дүн	36955	15,401,240.00	45,728	13,741,806.73	89.2%		
	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах		320,000.00	3,656	304,590.42	95.2%	

5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны болон бизнес эрхлэхийг дэмжих санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	494	4,940,000.00	1,233	4,619,830.00	93.5%
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	3000	90,000.00	2,462	71,764.00	79.7%
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		516,240.00	826	197,324.82	38.2%
		Дүн	3494	5,866,240.00	8,177	5,193,509.24	88.5%
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	1000	5,000,000.00	1,991	4,863,600.00	97.3%
		Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	430	430,000.00	425	206,202.33	48.0%
		Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	4000	500,000.00	3,849	436,033.93	87.2%
		Дүн	5430	5,930,000.00	6,265	5,505,836.26	92.8%
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	780	54,600.00	733	45,150.00	82.7%
		Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	130	54,600.00	130	16,643.90	30.5%
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	420	2,100,000.00	643	2,057,950.00	98.0%
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		336,000.00	910	160,499.87	47.8%
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	2800	84,000.00	2,254	66,697.50	79.4%
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	600	174,000.00	726	148,621.21	85.4%
		Ажил олгогчийн урамшуулал	78	296,880.00	44	146,307.20	49.3%
		Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох	184	920,000.00	182	901,000.00	97.9%
Дүн	4992	4,020,080.00	5,622	3,542,869.68	88.1%		
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	800	672,000.00	933	476,428.60	70.9%
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	272	816,000.00	409	807,500.00	99.0%
		Дүн	1072	1,488,000.00	1,342	1,283,928.60	86.3%
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дүн	58803	35,716,760.00	237,130	31,489,969.77	88.2%	
9	Жижиг зээл						
10	Хүүгийн хөнгөлөлт	58	20,000.00	6	10,126.34	50.6%	
11	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих		198,000.00		176,570.38	89.2%	
12	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт		100,000.00		97,464.34	97.5%	

13	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сан, бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах		600,000.00		520,598.19	86.8%	
14	Хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт, ажил олгогч, ажилтны байгууллагатай хамтарсан бүсийн сургалт, зөвлөгөөн		470,000.00		418,242.58	89.0%	
15	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг		1,022,000.00		824,705.09	80.7%	
16	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хөндлөнгийн үнэлгээ хийлгэх		363,643.00		281,019.18	77.3%	
17	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа		320,000.00		212,790.85	66.5%	
18	Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх, хэвлүүлэх		250,000.00		228,780.23	91.5%	
19	Хараагүйчүүдийн үйлдвэрийн үйл ажиллагааг сайжруулах төсөл		250,000.00		249,994.00	100.0%	
20	Хүүхэд хамгаалагч төсөл		460,000.00	274	312,899.00	68.0%	
21	Япон улсад ур чадвартай ажилтаны хөтөлбөрийг сурталчлах, уулзалт, гэрээ хийх болон бусад улс оронд сургалт, уулзалтад оролцох, өдөрлөг яармаг зохион байгуулах		300,000.00		38,887.07	13.0%	
22	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцийн хэрэгжилт, сургалт зохион байгуулах		225,000.00		203,482.31	90.4%	
23	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	Итгэлийн зээл	1,900,000.00	177	1,844,985.28	97.1%	
		Сургалт, сурталчилгаа хяналт үнэлгээний зардал	183,000.00		76,336.22	41.7%	
24	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хуваарилах суралцагчдын тэтгэлэг		41,004,000.00		18,588,300.00	45.3%	
ХЭДС-ийн зарлагын дүн			58,861	83,382,403.00	237,410	55,575,150.80	66.7%
25	Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт	Хандлага төлөвшил харилцааны чадварын сургалт	2,500	70,000.00			0.0%
		Компьютер, цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт	2,500	70,000.00			0.0%
		Хувь хүний санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт	2,500	42,000.00			0.0%
		Мэргэжлийн танхимын сургалт (7-9 долоо хоног)-ын дундаж зардал	2,500	612,500.00			0.0%
		Суралцагчид олгох хоол унааны хөнгөлөлт (12 сар өдрийн 5000, сарын 105,000₮)	2,500	262,500.00			0.0%
		Ажлын байран дээрх дадлага		214,720.00			0.0%

		Гарын авлага бэлтгэх, хэвлэх		40,000.00		17,220.00	43.1%
		Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг олон нийтэд хүргэх мэдээлэл, сурталчилгаа		34,000.00		19,197.50	56.5%
		Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын хяналт үнэлгээ		16,200.00			0.0%
		Дүн	12,500	1,361,920.00		36,417.50	2.7%
26	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн өмнөх болон зээлийн дараах санхүүгийн бус дэмжлэг	Зээлийн өмнөх сургалт	8,008	96,096.00	1,664.00	15,557.98	16.2%
		Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ	1,602	383,583.20	775.00		0.0%
		Жижиг зээлийн танилцуулга гарын авлага бэлтгэх, хэвлэх		6,000.00	775.00	6,000.00	100.0%
		Жижиг зээлд хамрагдах иргэний бүртгэлийн маягт хэвлэх		1,720.80	775.00		0.0%
		Бичил бизнес эрхлэгчдэд мэдээлэл зээл, санхүүгийн бус үйлчилгээний талаар мэдээлэл түгээх		6,300.00	775.00	4,300.00	68.3%
		Бичил бизнес эрхлэгчдийн дэмжих арга хэмжээний хяналт, үнэлгээ		6,300.00	775.00		0.0%
		Дүн	9,610	500,000.00	5,539.00	25,857.98	5.2%
27	Орон нутгийн санаачлагын төсөл	Орон нутгийн санаачлагын төсөл		1,275,900.00			0.0%
		Дүн		1,275,900.00			0.0%
28		Жижиг зээл		8,000,000.00		8,000,000.00	100.0%
		Дэлхийн банкны төслийн зарлагын дүн		11,137,820.00	5,539.00	8,062,275.48	72.4%
		Нийт зарлагын дүн		94,520,223.00		63,637,426.28	
		Сангийн яам татан төвлөрүүлэлт /үлдэгдэл/				96,626,319.38	

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн
01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
2020 ОНЫ ТӨСВИЙН ХУВААРЬ**

№	Үзүүлэлт	Зардлын жишиг хэмжээ	Төлөвлөгөө		
			хүн	Хөрөнгө /мян.төг/	
1	Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө			50,303,970.0	
2	Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө				
3	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж			22,500,000.0	
4	Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого			40,372,677.0	
5	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого			1,300,000.0	
6	Жижиг зээлийн эргэн төлөлт				
7	Жижиг зээлийн хүү, алданги			840,950.0	
8	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт				
9	Өмнөх оны үлдэгдэл			30,196,403.0	
	Орлогын дүн			145,514,000.0	
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	6.0 / 12.0		940,000.0	
2	Ажилд зуучлах үйлчилгээ	7.0		940,000.0	
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	45.0	4000	180,000.0
		Үйлдвэрлэл дээрх сургалт	700.0	243	170,000.0
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	230.0	1413	325,000.0
		Дүн		5656	675,000.0
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	5,000.0	1440	7,200,000.0
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт			516,240.0
		Аж ахуй эрхлэлтийн сургалт	30.0	5000	150,000.0
		Ажил олгогчийн урамшуулал	6,000.0	166	996,000.0
		Нийтийг хамарсан ажил	280.0	11585	3,244,000.0
		Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ	1,875.0	600	1,125,000.0
		Цагийн ажилд зуучлах	7.0	15000	105,000.0
		Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	500.0	2000	1,000,000.0
		Дүн		35791	14,336,240.0
	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах зардал	10,000.0	45	450,000.0	

5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны болон бизнес эрхлэхийг дэмжих санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	10,000.0	281	2,810,000.0
		Аж ахуй эрхлэлтийн сургалт	30.0	3000	90,000.0
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт			516,240.0
		Дүн		3326	3,866,240.0
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	5,000.0	800	4,000,000.0
		Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ		665	800,000.0
		Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт		2000	240,000.0
		Дүн		3465	5,040,000.0
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	70.0	1180	82,600.0
		Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	420.0	249	104,600.0
		Санхүүгийн дэмжлэг /50 хувь эргэн төлөгдөх/	5,000.0	420	2,100,000.0
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт			354,640.0
		Аж ахуй эрхлэлтийн сургалт	30.0	2800	84,000.0
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	290.0	600	174,000.0
		Ажил олгогчийн урамшуулал	5,040.0	75	378,000.0
		Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох	5,000.0	184	920,000.0
		Дүн		5508	4,197,840.0
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	840.0	800	672,000.0
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	3,000.0	272	816,000.0
		Дүн		1072	1,488,000.0
9	Засгийн газрын шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр	Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн санхүүжилт (итгэлийн зээл)	20,000.0	225	4,500,000.0
		Сургалт, сурталчилгаа, хяналт, үнэлгээний зардал			450,000.0
		Дүн		225	4,950,000.0
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дүн				55043	36,433,320.0
9	Жижиг зээл				
10	Жижиг зээлийн хүүгийн хөнгөлөлт	350.0	400	140,000.0	
11	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих			198,000.0	
12	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт			100,000.0	

13	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сан, бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах				845,600.0
14	Хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт, зөвлөгөөн				600,000.0
15	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг				900,000.0
16	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ ХНХЯ, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс хөндлөнгийн үнэлгээ хийлгэх				457,880.0
17	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа				220,000.0
18	Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх, хэвлүүлэх				250,000.0
19	Хүүхэд хамгаалагч төсөл			215	500,000.0
20	ЕБС-н сурагчдын мэргэжлийн чиг баримжаа олгох "Хөдөлмөр сургалтын танхим" төсөл				500,000.0
21	Япон, БНСУ-д хөдөлмөр эрхэлж буй иргэдийн асуудлаар сурталчилгаа, уулзалт, гэрээ хийх болон бусад улс оронд сургалт, уулзалтад оролцох, өдөрлөг яармаг зохион байгуулах				578,000.0
22	Жижиг зээлийн хүүгийн зардал	Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу төлөх хүүгийн төлбөр			600,000.0
23	ХБИ холбоодтой хамтран хэрэгжүүлэх төслийн санхүүжилт: Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлийн хяналт үнэлгээ, ТББ чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа, ХБИ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих мэдээлэл, нийтлэл, контент хөгжүүлэх, ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих стандарт дүрэм, журам боловсруулах үйл ажиллагаа				325,000.0
24	Засгийн газар, ХЭҮЗөвлөлийн шийдвэрээр тодорхойлогдсон бусад төсөл хөтөлбөр	ХЭД хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх чиглэлээр шинэ контент бүтээх, эмэгтэйчүүд, залуучууд зэрэг зорилтот бүлгийн судалгаа мэдээлэл гэх мэт.			420,200.0
ХЭДС-ийн зарлагын дүн				55658	43,068,000.0
25	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт			2,500,000.0
		Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээл		900	18,000,000.0
		Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүгийн бус дэмжлэг		15137	1,000,000.0
		Орон нутгийн санаачилгын төсөл			1,000,000.0
		Дүн		16037	22,500,000.0
26	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хуваарилах суралцагчдын тэгтгэлэг		200.0	39973	79,946,000.0
ХЭДС-ийн нийт зарлагын дүн				111668	145,514,000.0